



СОЁМБОМЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.30. №85 (85)

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ХЯНАН ШАЛГАГЧ БХЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУДАД ҮҮРЭГ ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба нар өчигдөр БХЯ-ны харьяа байгууллагын удирдлагуудтай уулзлаа. Энэ үеэр байгууллага бүрийн сүүлийн үед хийж байгаа ажлын тайланг сонсов. ҮБХИС-ийн хувьд энэ сарын 10-наас эхлэн Цэргийн мэргэжлийн сургалт эхлэн явагдаж байгаа. Мөн сонсогчид Таван толгой дахь сургалтын нэгдсэн төв, Шар хадны полигонд хээрийн сургалт дадлагад гарсан талаар мэдээллийг өглөө. Түүний дараа Багабаян ТӨААТҮГ-ын тухайд Афганистан Улсад үүрэг гүйцэтгээд эх орондоо ирсэн цэргийн алба хаагчдыг тусгаарлах ажлыг зохион байгуулсан талаар, Монгол Цэргийн музейн хувьд ОХУ-ын Цэргийн төв музейтэй хамтран “Орчин үед музейд ямар шаардлага тавигдаж байна вэ” сэдэвт цахим сургалт, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран “Эд хэрэглэлийг хэрхэн хамгаалах, арчлах нь” сургалтыг зохион байгуулсан болохоо тайлагнав.

Батлан хамгаалах Төв архивын тухайд Архивын лавлагаа мэдээллийг цахимаар өгч эхэлсэн бөгөөд өдөр бүр тогтсон цагт 2 удаа Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн шалганы байрнаас

тарааж байгаа гэв. Үүний дараа “Алдар” спорт хороо, Цэргийн төв эмнэлэг, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл, “Соёмбо” редакц болон бусад байгууллага дараалан тайлангаа тавьсан юм. Үүний дараа Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар нийтэд хамааралтай болон байгууллага тус бүрд хандаж чиглэсэн үүрэг өглөө. Үүнд, Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам, бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллах.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн ХЭГ/1636 дугаар албан бичгийн дагуу бие бүрэлдэхүүний 70 хүртэлх хувийн ээлжийн амралтыг олгох ажлыг зохион байгуулах.

Батлан хамгаалахын сайдын” Архидан согтууруулахтай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” 2021 оны А/83 дугаар тушаалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

Ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэж явах, цэргийн дүрэмт хувцас өмсөн үедээ архи, согтууруулах ундаа хэрэглэх, зодоон цохионы асуудал гаргасан,

эрүүгийн хариуцлага хүлээсэн албан хаагчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн албанаас халах хүртэл арга хэмжээг авч ажиллах.

Төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ажилдаа хандах хандлагыг өөрчлөхөд анхаарах. Мөн ёс зүйтэй, хариуцлагатай байж, хамт олноо үлгэрлэн манлайлж, эв нэгдлийг нь эрхэмлэн ялгаварлан гадуурхах, зүй бусаар харилцах, нэр хүндэд нь халдаж, гутаан доромжлох, аймган сүрдүүлэх, дарамтлах аливаа үйлдлийг гаргахгүй байхад онцгой анхаарах. Төрийн албан хаагчийн манлайлал, үлгэр дуурайллыг сайжруулах, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хууль дүрмийг сахих зан үйлийг төлөвшүүлэх, байгууллага, хамт олны ёс зүйтэй зөв соёлыг дэмжих механизмыг бүрдүүлэхэд анхаарч, бие биеэ харилцан хүндэлсэн уур амьсгал, орчныг бүрдүүлж, хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх соёл, дэг журмыг хэвшүүлэх.

Алба хаагч нэг бүртэй ёс зүйн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих, байгууллага, аж ахуйн нэгжид сахилга, дэг журам, ажлын

зохион байгуулалт, албаны хариуцлагыг дээшлүүлж, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэх, дагаж мөрдөх тал дээр онцгойлон анхаарах хэрэгтэй. Мөн байгууллагын харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэлтийг Цэргийн нийтлэг дүрмийн дагуу зохион байгуулан хяналт тавих, офицер, ахлагч, ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг камерын хяналтын систем болон халдвар хамгааллын дэглэмийг баримтлан байнга бүртгэж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа автомашиныг зөвхөн ажлын цагаар ашиглах, хувийн хэрэгцээнд ямар нэгэн байдлаар ашиглахгүй байхаас гадна төсвийн хэмнэлтийн тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, Батлан хамгаалах яамны холбогдох албан тушаалтнуудаас зөвшөөрөл авалгүйгээр бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ, хэлэлцээр хийхгүй байх, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хүлээн авч, бүртгэн нягтлан шалгаж, шийдвэрлэх, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, хариу хуулийн хугацаанд багтаан өгч байх, шийдвэрлэгдээгүй өргөдөл, гомдлын талаар удирдах албан тушаалтнуудад тогтмол мэдээлж байх зэрэг болно. Мөн нэмэлтээр төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл задрах, түүнээс урьдчилан сэргийлэх хяналт тавих ажил суларч байгаад анхаарах, цахим, хурал зөвлөгөөний давтамж нэмэгдэхтэй холбогдуулан албаны мэдээлэл болон нууцын горим алдагдахаас сэргийлэх, байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг эртнээс зохион байгуулж 2021 онд Цэргийн тэтгэвэр тогтоолгох санал ирүүлсэн албан хаагчдаа чөлөөлөхөд бэлдүүлэх, уулзаж үүрэг, чиглэл өгөх зэрэг нийтлэг үүргийг өглөө. Үүний дараа байгууллага бүрд чиглэсэн үүргийг өглөө.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
9	7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	24

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
29	16

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.367.00	3.427.00
CNY	438.60	443.00
RUB	38.90	40.60
JPY	25.48	25.97
KRW	2.43	2.57

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 21
2021.06.30.
/ЛХАГВА ГАРАГ/

ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

04.57-20.55

Барилдлага:

Үхэх


Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Суудал:

Уул
Өнөөдөр аргын тооллын 2021 оны зургаадугаар сарын 30. Лхагва гараг. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адуус муулах, гарагийг тахиж, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулах, нарийн зөвлөгөөн хийх, улаа гаргах, хиншүү хярвас гарагахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогосод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ХОС РОМБО, ДИПЛОМ ГАРДСАН АНХНЫ ОЮУТАН



Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Санхүү эдийн засгийн их сургуулийн хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд дотоодын хамтарсан эдийн засаг, санхүүгийн

“2.5+1.5” хөтөлбөрөөр Аюулгүй байдлын дээд сургуулийн Эдийн засаг, менежментийн тэнхимийн оюутан Бямбажавын Амирлангуй амжилттай суралцаж хос диплом, хос ромбоо гардан авлаа.

Б.Амирлангуй нь ҮБХИС-ийн АБДС-ийн ЭЗМТ-ийг эдийн засгийн мэргэжлээр, СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийг санхүүгийн шинжээч мэргэжлээр тус тус суралцан 3.5 голч үнэлгээтэй төгссөн юм. Оюутан Б.Амирлангуй нь амжилттай суралцаж ХХБ-нд Борлуулалт мэдээллийн ажилтнаар ажлын анхны гараагаа эхэлж байгаад эрдэмтэн багш нар нь халуун баярыг хүргэж, цаашдынх нь ажил амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөлөө.

НААДМЫН ҮЕЭР ЕС ХОНОГ АМАРНА



Баяр наадмын үеэр буюу 7 дугаар сард албан байгууллагуудыг ес хоног амрахаар тогтжээ. Тодруулбал, иргэд 7 дугаар сарын 10-18-нд буюу нийт ес хоног амарч, 7 дугаар сарын 24-ний бямба гарагт ажил цуглах юм.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд Үндэсний их баяр наадмаар

11-15-нд амрахаар заасан байдаг. Харин энэ жилийн тухайд 7 дугаар сарын 16-нд баасан гарагт таарч байгаа тул тус ажлын өдрийг 7 дугаар сарын 24-нд шилжүүлж, 10-18-ныг дуустал амрахаар Засгийн газраас шийдвэрлэжээ. Энэ хугацаанд хөдөлгөөний нягтаршлыг бууруулах, иргэдийг гэр бүлийн хүрээнд амрах нөхцөлийг бүрдүүлнэ гэж Эрүүл мэндийн сайд мэдээллээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

113.232

ЭДГЭРСЭН

73.007

НАС БАРСАН

548/15

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

3372(58)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

336

ЭДГЭРСЭН

2976

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 181,601,447

Эдгэрсэн

Нийт:

Нас барсан

Нийт: 3,932,925



ХУУХДИЙГ
КОРОНАВИРУСТ
ХАЛДВАР (КОВИД-19)-
ААС СЭРТГИЙЛЬЕ!

